

БАТЛАВ:

ЗАХИАЛАГЧ
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ
И. *Д. Баярсайхан* ЗАХИРАЛ
Ц. БИЛЭГТСАЙХАН



**ВАКЦИН, БИОБЭЛДМЭЛИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ АГУУЛАХЫН УРСГАЛ ЗАСВАРЫН
АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

Дугаар АГ/22/173

Улаанбаатар хот

Нэг талаас: Халдварт өвчин судлалын үндэсний төвийг төлөөлж Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал Д.Баярсайхан цаашид /захиалагч тал гэх/.

Нэгөө талаас: 5797276 регистрийн дугаартай, Баянзүрх дүүрэг 6 дугаар хороо, 23-4 тоот байрлах "Платинум их өргөө констракшн" ХХК (цаашид "гүйцэтгэгч" гэх)-ийг төлөөлж захирал Т.Билгүүн /цаашид Гүйцэтгэгч гэх/ Монгол улсын Иргэний хуульд заасан нийтлэг үндэслэл болон мөн хуулийн 243-261 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтуудыг үндэслэн хоёр байгууллагын даргын олгож, зөвшөөрсөн эрх хэмжээний хүрээнд доорх нөхцлүүдийг харилцан тохиролцож 2022 оны 10 дугаар сарын 18-ний өдөр энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Гэрээний зорилго нь Халдварт өвчин судлалын үндэсний төв нь Вакцин, биобэлдмэлийн үндэсний төв агуулахын урсгал засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/-ны барилгын их засварын ажил /цаашид ажил гэх-/ыг захиалж, гүйцэтгүүлэх, Платинум их өргөө констракшн ХХК нь төвийн захиалсан ажлыг гүйцэтгэхтэй холбогдсон харилцаа болон гэрээний талуудын эрх зүйн байдлыг тогтоож зохицуулахад чиглэгдэнэ.

1.2. Энэхүү гэрээ нь Монгол улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

1.3. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "гэрээний бичиг баримт" гэх). Үүнд:

- 1.3.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 1.3.2 Бусад шаардлагатай баримт бичиг;
- 1.3.3 Унийн санал
- 1.3.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 1.3.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 1.3.6 Техникийн тодорхойлолт;
- 1.3.7 Зураг;
- 1.3.8 Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь.
- 1.3.9 Санхүүжилтийн хуваарь.
- 1.3.10 Ажил гүйцэтгэх хуваарь.

1.4. Энэхүү гэрээ нь ажлыг захиалж, гүйцэтгэх талаар гэрээ байгуулахаас өмнөх шатанд хэлэлцэх, зөвлөлдөх, тодруулга, тайлбар авах, өгөх зөргээр талуудын үйлдсэн бүх хэлцлийг эцэслэн нэгтгэж, тохиролцсон албан ёсны эрх зүйн баримт бичиг болно.

1.5. Хэрэв гэрээний салшгүй хэсэгт тооцоогоор энэхүү гэрээний 1.3 дахь хэсэгт заасан бичиг баримтууд өөр хоорондоо зөрчилдвэл мөн хэсэгт заасан дарааллын дагуу өөр хооронд нь уялдаатай байдлаар ач холбогдол өгч, шийдвэрлэнэ.

ХОЁР. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Гүйцэтгэгчтэй байгуулсан энэхүү гэрээгээр тогтоосон графикт хугацаанд захиалсан ажлыг нэр, төрөл, тоо хэмжээгээр хүлээн авах ба тогтоосон хугацаанд ажлыг гүйцэтгэхийг гүйцэтгэгчээс шаардана.

2.2. Захиалагч нь ажлыг төвийн шаардлага тавьсан техникийн тодорхойлолтод заасан шаардлагатай тохирч байгаа эсэхийг шалган хүлээж авна. Хэрэв гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажил төвөөс шаардсан техникийн тодорхойлолтой тохирохгүй бол хүлээн авахаас татгалзана.

2.3. Захиалгат ажлыг хүлээн авсан өдрөөс хойш 21 хоногийн дотор үнийг нь төлнө.

2.4. Гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын бүх нэр төрлийг 100 хувь худалдан авах ба шаардлагатай тохиолдолд ажлын үнийг өсгөхгүйгээр “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх хэсгийг үндэслэн гэрээний анхны үнийн дүнгийн 15 хүртэл хувиас хэтрүүлэхгүйгээр ажлын тоо хэмжээг нь нэмэгдүүлэх эрхтэй. Энэ тохиолдолд гэрээнд нэмэлт оруулж талууд баталгаажуулах бөгөөд энэхүү нэмэлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

2.5. Халдварт өвчин судлалын үндэсний төвд шинээр нэвтэрч буй технологи, тухайн жилийн өвчлөлийн байдал, төсөв санхүүгийн эрсдэлтэй байдал, давтагдашгүй бусад хүчин зүйл зэрэг захиалагч урьдчилан харах боломжгүй нөхцөл байдал үүссэний улмаас гэрээнд зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд төрийн эрх бүхий байгууллагад танилцуулсаны үндсэн дээр гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын тоо хэмжээг гэрээний анхны үнийн дүнгийн 15 хүртэлх хувиар бууруулж болно. Энэ тохиолдолд гэрээнд оруулах өөрчлөлтийг талууд албан ёсоор баталгаажуулах бөгөөд гэрээний өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

2.6. Гэрээгээр гүйцэтгэвэл зохих ажлыг нэр төрлөөр, тоо хэмжээгээр дутуу гүйцэтгэсэн, эсхүл хуваарийн дагуу гүйцэтгэх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд захиалгат ажлыг гүйцэтгэх хуваарын өдрийн дараагийн өдрөөс эхлэн гүйцэтгээгүй ажлын үнийн дүнгээс энэ гэрээний 5.4-д заасан алдангийг тооцно.

2.7. Гүйцэтгэгч талын гэрээний үүргийн хэрэгжилтэд хяналт тавих албан тушаалтны мэдээлэл, тайланг сар бүр танилцан зөвлөмж, чиглэл өгч гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, холбогдох мэдээллийг зохих журмын дагуу худалдан авах ажиллагааны цахим системд оруулна.

2.8. Хуулиар тогтоосон үндэслэл, эрх хэмжээний хүрээнд гэрээг цуцлах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг гүйцэтгэгчид хүргүүлнэ.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Захиалагчийн захиалсан ажлыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох гүйцэтгэх ажлын жагсаалт болон хуваарийн дагуу гүйцэтгэнэ.

3.2. Захиалагчтай тохиролцож энэхүү гэрээгээр тогтоосон нөхцөл шаардлагын дагуу ажлыг гүйцэтгэх ба хүлээлгэн өгөх үед шаардлага хангаагүй ажлыг захилагчийн тогтоосон хугацаанд яаралтай нөхөн гүйцэтгэнэ.

3.3. Захиалагчтай тохиролцон энэхүү гэрээний салшгүй хэсэг болох захиалж, гүйцэтгүүлэх ажлыг жагсаалтад заагдсан нэршлээс өөр төрлийн ажлаар орлуулж гүйцэтгэхгүй байх үүрэг хүлээнэ.

3.4. Гэрээгээр гүйцэтгэх ажлыг нэр төрлөөр, тоо хэмжээгээр дутуу гүйцэтгэсэн, эсхүл гүйцэтгэхээр тохиролцсон хуваарын хугацааг хэтрүүлсэн тохиолдолд ажлыг гүйцэтгэвэл зохих өдрийн дараагийн өдрөөс эхлэн хоног тутам гүйцэтгээгүй ажлын үнийн дүнгээс энэ гэрээний 5.4-д заасан алданги төлнэ.

3.5. Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын чанарын доголдол болон давагдашгүй хүчин зүйлд тооцохоор энэ гэрээний 3.4-д зааснаас бусад тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг хэтрүүлсний улмаас хүний амь нас эрсэдсэн, эрүүл мэндэд хохирол учирсан бол үр дагаврыг бүрэн хариуцна;

3.6. Захиалгат ажлыг захилагчтай тохиролцон баталсан хуваарийн дагуу тухайн сарын ажлын эхний 5 хоногт багтаан гүйцэтгэнэ;

3.7. Гүйцэтгэгчийн хүсэл зоригоос шалтгаалаагүй урьдчилан харах боломжгүй байсан зайлшгүй нөхцөл байдлын улмаас гүйцэтгэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ өөрчлөгдхөн болон захиалгат ажлыг хуваарын хугацаанд гүйцэтгэх боломжгүй асуудал үүссэн тохиолдолд нөхцөл байдал үүссэнээс хойш 24 цагийн дотор захиалагч талд мэдэгдэнэ.

3.8. Энэ гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдэд шилжүүлэхгүй ба өөрөө гүйцэтгэнэ.

3.9. Захиалагч талыг гэрээний үүргээ биелүүлэхийг болон гүйцэтгэсэн ажлынхаа үнийг нэхэмжилж шаардах эрхтэй.

3.10. Гэрээ цуцлах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал тавих эрх эдэлнэ.

ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

4.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж баталгаажуулсан 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл хугацаанд үйлчилнэ.

4.2. Гэрээг 3 хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр ижил хууль зүйн хүчин чадалтай байна.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТҮҮНИЙГ ТӨЛӨХ

5.1. Талуудын тохиролцсоноор Платиниум их өргөө констракши ХХК-иас Халдварт өвчин судлалын үндэсний төвд захиалгаар гүйцэтгэх ажлын нийт үнэ 77,616,038 (далан долоон сая зургаан зуун арван зургаан мянга гучин найман) төгрөг байна.

5.2 Гэрээний үнийн дүнгээс 2022 онд гүйцэтгэх ажлын дүн 77,616,038 төгрөг байна. Үүнээс зураг төслийн ажлын дүн 500,000 төгрөг байна.

5.3 Захиалагч нь засварын ажлыг хурдан шуурхай гүйцэтгүүлэх үүдний урьдчилгаа санхүүжилт 40%, явцын санхүүжилт 30%, ажил дуусгаж хүлээлгэн өгч холбогдох бичиг баримт, акт үйлдсэний дараа үлдэгдэл 30% -ийн санхүүжилтыг шилжүүлж тооцоог дуусгана.

5.4. Захиалагч ажлыг хүлээн авсан өдрөөс хойш 21 хоногийн дотор үнийг нь төлнэ.

5.5. Гэрээгээр гүйцэтгэх ажлыг нэр төрлөөр, тоо хэмжээгээр дутуу гүйцэтгэсэн, эсхүл хуваарийн дагуу гүйцэтгээгүй, хугацааг хэтрүүлсэн тохиолдолд гэрээт ажлыг

гүйцэтгэвэл зохих хуваарыт өдрийн дараагийн өдрөөс эхлэн гэрээний үнийн дүнгээс хоног тутам 0.05 хувийн алданги тооцон гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авна.

ЗУРГАА. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

6.1. Энэхүү гэрээний хавсралтад заасан гүйцэтгэх ажлын нэг бүрийн үнэ нь энэ гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд өөрчлөгдөхгүй байх нөхцөлийг талууд хатуу мөрдөнө.

6.2. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан үндэслэл, журмыг дагаж мөрдөнө.

6.3. Гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд энэхүү гэрээгээр талуудын тохиролцон тогтоосон захиалгаар гүйцэтгэх ажлын нэр төрөл, тоо хэмжээг өөрчлөхгүй байхыг эрмэлзэнэ. Өөрчлөх зайлшгүй шаардлагатай нөхцөл байдал үүссэн бол ажлын 2 хоногт багтаан нөгөө талдаа мэдэгдэж, ажлын 5 хоногийн дотор талууд асуудлыг зөвшилцэн шийдвэрлэж, шийдвэрийг бичгээр үйлдэн баталгаажуулна. Талуудын гаргасан шийдвэр гэрээний салшгүй хэсэг болох тул талууд гаргасан шийдвэрийн дагуу хүлээсэн үүргээ гэрээний үүргийн нэг ижил биелүүлнэ.

6.4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2 дахь хэсэгт заасны дагуу суурь үнэ огцом өөрчлөгдсөн болохыг Засгийн газар, эдийн засаг, санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн тохиолдолд талууд харилцан тохиролцож гэрээний үнэд тохицуулга хийнэ.

ДОЛОО. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

7.1. Энэхүү гэрээний 4.1-д заасан хугацаа дууссан өдөр энэ гэрээний үйлчлэл дуусгавар болно.

7.2. Гэрээний аль нэг тал татан буугдах, дампуурах зэргээр үйл ажиллагаа дуусгавар болж гэрээний үүрэг өөр бусад этгээдэд шилжээгүй тохиолдолд холбогдох байгууллагын шийдвэр гарсан өдөр гэрээний үйлчлэл дуусгавар болно.

7.3. Гэрээг хугацааны өмнө дараах үндэслэлээр цуцалсан тохиолдолд гэрээ хугацааны өмнө дуусгавар болно. Үүнд:

7.3.1. Гүйцэтгэгч тал чанарын шаардлага хангахгүй ажлыг гүйцэтгэсний улмаас үйл ажиллагаанд хохирол учирсаныг мэдэгдсэн байхад энэ зөрчлийг давтан гаргасан;

7.3.2. Энэ гэрээгээр гүйцэтгэхээр заасан ажлыг өөр төрлийн ажлаар орлуулан нийлүүлэхээр ирүүлснийг дахин гаргахгүй байх талаар төвөөс бичгээр мэдэгдэл хүргүүлсэн боловч зөрчлөө давтан гаргасан;

7.3.3. Гүйцэтгэгч тал ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүйгээс төвийн тусламж, үйлчилгээний хэвийн байдал алдагдаж үйлчлүүлэгчийн хохироосон нь төвийн чанар, дотоод хяналтын албаны болон холбогдох төрийн мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт, шалгалтын дүгнэлтээр тогтоогдсон;

7.3.4. Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гүйцэтгэсэн ажлын үнийг төлөх хугацааг удаа дараа хэтрүүлж, гүйцэтгэгчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй;

8.1. Гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдох асуудлаар албан бичиг буюу телекс, цахилгаан болон факсаар харилцана.

8.2. Энэхүү гэрээний хэрэгжилтийг гэрээ дууссан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан талуудын төлөөлөл бүхий бүрэлдэхүүн дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

8.3. Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр зэрэг талуудын хүсэл зориоос үл хамаарах шалтгааны улмаас гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүсэн гарах үр дагаврыг хариуцахгүй.

ЕС. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

9.1. Гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд талуудын хооронд үүссэн маргааныг аль болох зөвшилцөн шийдвэрлэнэ.

9.2. Хэрэв зөвшилцөн шийдвэрлэж чадахгүй бол шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа
эрхэлсэн дэд захирал

Д.Баярсайхан

Хангамж, хийлчилгээ, инженерийн
технологийн албаны дарга

Н.Батням

Эдийн засагч

А.Шинэхүү

ХАЯГ: УБ-48, Баянзүрх дүүрэг, 14-р
хороо Нам-Ян-Жүгийн гудамж

УТАС: 451185, 453994

Харилцагч банкны нэр: Төрийн сан

Дансны дугаар: 100900020010

Регистрийн дугаар: 9077901

ГҮҮЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

УЛААНБААТАР ХОТ

Платинумынх өргөө констракши
ХХК-ийн захирал
Т.Билгүүнх

ХАЯГ: Улаанбаатар хот, Баянзүрх
дүүрэг
6 дугаар хороо, 23-4 тоот

УТАС: 99111054

Харилцах банкны нэр: Төрийн банк

Дансны дугаар: 109000159761

Регистрийн дугаар: 5797276